БАТЛАВ
ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.ДАВААНЯМ
20... оны ... дугаар сарын ...

# САНГИЙН ДАЛАЙ БАГИЙН ТӨВИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

20... оны ... дугаар сарын ... Мандалтолгой

Багийн төвийн барилгын хэмжээ: Барилга нь 12*10 харьцаатай таамбар 2*2м харьцаатай байна.

- ✓ Барилгын суурь: Газрын гадаргаас доош 30см, газрын гадаргаас дээш 20см бетон цутгаж хийх. Барилгын суурийн өргөн 45-50см байх.
- ✓ Барилгын хана:Блок-Хөөс-Улаан тоосгоор барих.Шалнаас тааз хүртлэх ханын өндөр 2,4м
- ✓ Барилгын доторх тасалгаа: Багийн даргын өрөө 4*3м, усанд орох өрөө 3*3м, эмчийн өрөө 3*3м, хурлын заал 9*10м харьцаатай байна. Хурлын заал, Багийн Засаг даргын өрөө, усанд орох өрөөний тасалгааг ханан пийшингээр шийдэх
- ✓ Барилгаас 3м зайд бохирын цооногийг 4 ханыг цементэлж шийдвэрлэнэ. Цооног 2*2м харьцаатай, гүн нь 3м байна.
- ✓ Бохирын усыг зориулалтын хоолойгоор бохирын цооногтой холбох
- ✓ Барилгын тааз:15*15см харьцаатай палк модоор 1м зайтай дам нуруу тавих, банзаар хучилт хийж хар цаас, шилэн хөвөнгөөр дулаалах
- ✓ Таазны дотор талд лампер шахах
- ✓ Барилгын дээвэр: Шувуун нуруутай хийх, нурууны өндөр 1,2м, нурууг 15*7см харьцаатай банзаар, дээврийн төмөр 3мм зузаантай, хувил сайтай сайн чанарын төмрөөр хийх
- ✓ Барилгын цонх:Зааланд 1,0*1,5м хэмжээтэй 3 ширхэг сайн чанарын вакум цонх, багийн дарга болон эмчийн өрөөнд 1,0*1,5м хэмжээтэй тус бүр нэг нэг вакум цонхыг суурилуулж, цонхнууд битүү төмөр хамгаалттай байна.
- ✓ Барилгын хаалга: Стандарт хэмжээтэй 2 ширхэг модон хаалга, угаалгын өрөөнд 1 ширхэг вакум хаалга, үүдний хаалга нь сайн чанарын 1 ширхэг монгол хаалга, таамбарт 1 ширхэг хаалгыг рамм зангидаж зузаан төмрөөр хийх
- ✓ Барилгын шал: Шалан дээр 2м өргөн, 30см өндөртэй тайз хийх, шал болон тайзыг цемэнтээр цутгаж паркетэн шал шахах, тайз нь шаттай байна. Мөн тайзанд гүйдэг хөшиг хийсэн байна. Хурлын өрөөний шалыг резинэн шал хийх, Багийн Засаг даргын өрөө, эмчийн өрөөнд саарал өнгөтэй паркетан шал шахах
- ✓ Дотор засал: Ханыг цементэн шавраар өнгөлгөө хийж, замаск татаж, сайн чанарын солонгос эмульсээр өнгөлөх

- ✓ Цахилгаан монтаж: Барилгын цахилгааны монтаж гаднаас оролттой, 7 ширхэг разетик, гэрлийн унтраалга 6 ширхэг зэрэг стандартад нийцсэн цахилгаан холболт хийх
- ✓ Өрөөнүүдэд нийт 20 гэрлийг суурилуулсан байна.
- ✓ Халаалтыг ханан пийшин, энгийн зуухаар шийдэх.
- ✓ Усанд орох өрөөний хана нь хагас плита, шал нь бүтэн плита байна. Мөн халуун хүйтэн усны нөөцийн сав 200л багтаамжтай тус бүр нэг нэг ширхэг байна. Халуун усаа ханан пийшингээр халаадгаар хийх. Усанд орох өрөө нь дотроо тусгаарлах хөшигтэй байна.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Д.АЛТАЙ

БОЛОВСРУУЛСАН:

САНГИЙН ДАЛАЙ БАГИЙН

ЗАСАГ ДАРГА М.ТОГТОХМЭНД